

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/150/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.	14
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Сандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Аудитын гэрчилгээ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг
Утас/Факс: (976) 7032 3253
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.10 № 118
танай _____-ны № _____-т

АРВАЙХЭЭР СУМЫН 5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ЛҮНДЭЭЖАНЦАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн данснаас 1317.2 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол зөрчин хувцас худалдаж авсан, бичиг хэрэг, эмийн тооллого дутуу хийгдсэн, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан бэлтгээгүй, мөнгө хүсэх өргөдөл, бэлэн мөнгөний орлогын баримт, зарлагын баримт хөтлөөгүй, байгууллагын дотоод хяналтын ажлыг хангалтгүй зохион байгуулсан, санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлд тулган баталгаажуулах сорил гүйцэтгэхэд 2402.3 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн болох мах, цагаан будаа дутсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70.4.1 эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах гэсэн заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56800384.00</u>	<u>66700455.52</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	56800384.00	66700455.52
351	Түүхий эд материал	490000.00	1034420.00
35130	Эм бөх материал	490000.00	1034420.00
354	Хангамжийн материал	56310384.00	65666035.52
35410	Бичиг хэргийн материал	5500.00	572500.00
35420	Аж ахуйн материал	3040000.00	2909450.00
35460	Хүнсний материал	9988571.00	13307798.52
35470	Бусад хангамжийн материал	43276313.00	48876287.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>543847595.34</u>	<u>553867779.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	543847595.34	553867779.74
392	Биет хөрөнгө	453047595.34	462700280.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	442706877.53	472706877.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39261157.44	-61043910.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	93278891.85	88706667.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59192272.68	-58848976.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27812470.92	23553052.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18983793.84	-8330009.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	3650000.00	3650000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-729999.96
39217	Ном	3036579.00	3036579.00
393	Биет бус хөрөнгө	90800000.00	91167498.98
39301	Програм хангамж	490000.00	490000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-490000.00	-122501.02
39303	Бусад биет бус хөрөнгө	90800000.00	90800000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>600647979.34</u>	<u>620568235.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>600647979.34</u>	<u>620568235.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	600647979.34	620568235.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	234421810.20	234421810.20
51101	Өмч: - төрийн	234421810.20	234421810.20
512	Хуримтлагдсан үр дүн	65305795.65	85226051.57
51210	Өмнөх үеийн үр дүн	65305795.65	65305795.65
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	19920255.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	300920373.49	300920373.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>600647979.34</u>	<u>620568235.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	507467350.00	489613864.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30248500.00	48693280.52
120	Нийтлэг татварын бус орлого	30248500.00	48693280.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30248500.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,248,500.00	
120009	Бусад орлого		15663980.52
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		30000000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		3029300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477218850.00	440920584.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	431349850.00	396769000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	431349850.00	396769000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5116000.00	876784.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	736784.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3906000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210000.00	140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40753000.00	43274800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40753000.00	43274800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486127418.30	469693608.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486127418.30	469693608.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473154427.25	465516955.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327968948.51	317892408.00
210101	Үндсэн цалин	212464748.51	220019607.00
210102	Нэмэгдэл	88078900.00	76334419.00
210104	Урамшуулал	27425300.00	21538382.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41276344.44	41497398.68
210201	Тэтгэврийн даатгал	28151476.23	28976804.65
210202	Тэтгэмжийн даатгал	3297600.00	3220924.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2638014.83	2543139.21
210204	Ажилгүйдлийн даатгал	653570.60	614226.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6535682.78	6142303.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34384370.00	36376610.00
210301	Гэрэл, цахилгаан	3732485.00	2770731.00
210302	Түлш, халаалт	26901700.00	29466359.00
210303	Цэвэр, бохир ус	3750185.00	4139520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6084900.00	5423710.00
210401	Бичиг хэрэг	673300.00	362200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1011700.00	1511700.00
210404	Ном, хэвлэл	631400.00	111000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	721100.00	265360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3047400.00	3173450.00
2105	Нормативт зардал	24819860.00	18850632.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	382700.00	905580.00
210502	Хоол, хүнс	23755960.00	16985302.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	681200.00	959750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3702800.00	6593100.00
210604	Урсгал засвар	3702800.00	6593100.00
2107	Томилолт, зочны зардал	225900.00	225900.00
210702	Дотоод албан томилолт	225900.00	225900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1192500.00	1637000.00

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	868500.00	1637000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33498804.30	37020196.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4024600.00	284600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1339700.00	1091800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28134504.30	35643796.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12972991.05	4176653.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	2025000.00	2075000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2025000.00	2075000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2101653.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2101653.32
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10947991.05	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10947991.05	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21339931.70	19920255.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21339931.70	19920255.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	477218850.00	440920584.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477218850.00	440920584.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	431349850.00	396769000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	431349850.00	396769000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5116000.00	876784.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	736784.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3906000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210000.00	140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40753000.00	43274800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40753000.00	43274800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	477218850.00	440920584.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477218850.00	440920584.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464245858.95	436743930.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327724424.51	317892408.00
210101	Үндсэн цалин	212220224.51	220019607.00
210102	Нэмэгдэл	88078900.00	76334419.00
210104	Урамшуулал	27425300.00	21538382.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41276344.44	41497398.68
210201	Тэтгэврийн даатгал	28151476.23	28976804.65
210202	Тэтгэмжийн даатгал	3297600.00	3220924.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2638014.83	2543139.21
210204	Ажилгүйдлийн даатгал	653570.60	614226.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6535682.78	6142303.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34384370.00	36376610.00
210301	Гэрэл, цахилгаан	3732485.00	2770731.00
210302	Түлш, халаалт	26901700.00	29466359.00
210303	Цэвэр, бохир ус	3750185.00	4139520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12008600.00	6393584.00
210401	Бичиг хэрэг	526500.00	672700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1011700.00	1511700.00
210404	Ном, хэвлэл	221400.00	194640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	721100.00	265360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9527900.00	3749184.00

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	31896920.00	23946930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	872400.00	1652000.00
210502	Хоол, хүнс	29646820.00	20304530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1377700.00	1990400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5579800.00	6420100.00
210604	Урсгал засвар	5579800.00	6420100.00
2107	Томилолт, зочны зардал	225900.00	225900.00
210702	Дотоод албан томилолт	225900.00	225900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1192500.00	2237000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	868500.00	2237000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9957000.00	1754000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7734600.00	284600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2222400.00	1469400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12972991.05	4176653.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	2025000.00	2075000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2025000.00	2075000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2101653.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2101653.32
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10947991.05	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10947991.05	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	65,305,795.65	0.00	600,647,979.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	65,305,795.65	0.00	600,647,979.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	65,305,795.65	0.00	600,647,979.34
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	65,305,795.65	0.00	600,647,979.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	65,305,795.65	0.00	600,647,979.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,920,255.92	0.00	19,920,255.92
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,421,810.20	300,920,373.49	85,226,051.57	0.00	620,568,235.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470250300.00	472102850.00	440043800.00	440043800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470250300.00	472102850.00	440043800.00	440043800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468225300.00	459129858.95	437968800.00	435867146.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327749600.00	327724424.51	317892900.00	317892408.00
210101	Үндсэн цалин	212245400.00	212220224.51	217336600.00	220019607.00
210102	Нэмэгдэл	88078900.00	88078900.00	81404000.00	76334419.00
210104	Урамшуулал	27425300.00	27425300.00	19152300.00	21538382.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44518100.00	41276344.44	43117600.00	41497398.68
210201	Тэтгэврийн даатгал	31327600.00	28151476.23	30579100.00	28976804.65
210202	Тэтгэмжийн даатгал	3297600.00	3297600.00	3134600.00	3220924.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2638100.00	2638014.83	2507700.00	2543139.21
210204	Ажилгүйдлийн даатгал	659500.00	653570.60	626900.00	614226.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6595300.00	6535682.78	6269300.00	6142303.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35693200.00	34384370.00	36854700.00	36376610.00
210301	Гэрэл, цахилгаан	4493900.00	3185070.00	3087900.00	2770731.00
210302	Түлш, халаалт	26901700.00	26901700.00	29466400.00	29466359.00
210303	Цэвэр, бохир ус	4297600.00	4297600.00	4300400.00	4139520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7892600.00	7892600.00	5956800.00	5956800.00
210401	Бичиг хэрэг	316500.00	316500.00	640300.00	672700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1011700.00	1011700.00	1511700.00	1511700.00
210404	Ном, хэвлэл	221400.00	221400.00	221300.00	194640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	721100.00	721100.00	271100.00	265360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5621900.00	5621900.00	3312400.00	3312400.00
2105	Нормативт зардал	36416600.00	31896920.00	23649800.00	23646930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	872400.00	872400.00	1352000.00	1352000.00
210502	Хоол, хүнс	34166500.00	29646820.00	20307400.00	20304530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1377700.00	1377700.00	1990400.00	1990400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5059800.00	5059800.00	6420100.00	6420100.00
210604	Урсгал засвар	5059800.00	5059800.00	6420100.00	6420100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712500.00	712500.00	2097000.00	2097000.00

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388500.00	388500.00	2097000.00	2097000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	324000.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9957000.00	9957000.00	1754000.00	1754000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7734600.00	7734600.00	284600.00	284600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2222400.00	2222400.00	1469400.00	1469400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2025000.00	2025000.00	2075000.00	2075000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2025000.00	2025000.00	2075000.00	2075000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2025000.00	2025000.00	2075000.00	2075000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	472102850.00	472102850.00	440043800.00	440043800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	431349850.00	431349850.00	396769000.00	396769000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	431349850.00	431349850.00	396769000.00	396769000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	1000000.00	1000000.00	736784.00	736784.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	3906000.00	3906000.00	140000.00	140000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210000.00	210000.00		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40753000.00	40753000.00	43274800.00	43274800.00
132001	Орон нутгийн төсвөөс	40753000.00	40753000.00	43274800.00	43274800.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5116000.00	876784.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5116000.00	876784.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5116000.00	876784.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4116000.00	436784.00
210401	Бичиг хэрэг	210,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,906,000.00	436,784.00
2105	Нормативт зардал	0.00	300000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	520000.00	0.00
210604	Урсгал засвар	520,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480000.00	140000.00

Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,000.00	140,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5116000.00	876784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5116000.00	876784.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	736,784.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,906,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.00	140,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын дотоод хяналт, шалгалтын ажил хангалтгүй зохион байгуулсан тул зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.01.31-наас 2022.02.07–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.07-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.26-ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бага дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.“Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь “ Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3.1. бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 469.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 45.7 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгджээ

Бараа материалын тодруулга тайлангаар 37.1 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 3.0 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 30.2 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд авлага, өглөггүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 2.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 396.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 43.3 сая төгрөг батлагдаж, 396.8 сая төгрөгийг улс, 43.3 орон нутгийн төсвөөс төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 0.9 сая төгрөгийн санхүүжилт авч бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 142 мэдээллийг ил тод мэдээлсэн, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил бүрэн хэрэгжсэн.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитын явцад 2.4 сая төгрөгийн хүнсний материал тооллогоор дутсан, 1.6 сая төгрөгийг ажилчдын хувцас бэлтгэх, уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг зөрчлийг санхүүгийн үр өгөөжөөр тооцож, хүлээн зөвшөөрүүлсэн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7928.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 акт, 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөлийн ажлыг сайжруулах талаар.

1.1. Илрүүлэлт:

Байгууллага нь дотоод хяналт шалгалтын нэгжтэй боловч хяналт шалгалт бүрэн хэрэгжээгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахад эрсдэл үүсэж байна..

1.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж дотоод хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх 1 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 01-ний** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Арвайхээр сумын 5-р цэцэрлэг	5	7.9			1	2.4	3	5.5	1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 10-НИЙ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 02/2022/150/НА-СИА-ТНУС/1590359/77 Арвайхээр

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Лүндээжанцан танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авч, уралдаан тэмцээн зохион байгуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.


Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 "Албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. р

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авсан, уралдаан тэмцээн зохион байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор **Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт** ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Лүндээжанцан, нягтлан бодогч М.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ц.МӨНХЗАЯА

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 081/2022/АСД/НА.ЦГА-Т.УС/Н/580359/26 Арвайхээр

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Лүндээжанцан танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын тооллогын комисс бичиг хэрэг, эм боох материалыг тоолоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70.4.1 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 12 дугаар зүйл 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан тооллогыг чанартай зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор **Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт** ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Лүндээжанцан, нягтлан бодогч М.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ
АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар ӨВАНЦ/2022/БСО/НА СТАТУС/11590351/75 Арвайхээр

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Лүндээжанцан танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар 2021 онд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан бэлтгээгүй, мөнгө хүсэх өргөдөл, бэлэн мөнгөний орлогын баримт, зарлагын баримт хөтлөөгүй зөрчил илэрсэн.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан анхан шатны бүртгэл дутуу хөтөлсөн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор **Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт** ирүүлэх;pp

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Лүндээжанцан, нягтлан бодогч М.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ц.МӨНХЗАЯА

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар ӨДА/2022/150/НА-СТА-ТШЗ/А/1590351/04 Арвайхээр

Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Лүндээжанцан танаа
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар 2021 оны хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлд тулгалт хийхэд үхрийн мах 194.65 кг мах, хонины мах 11.75 кг, цагаан будаа 232.5 кг дутсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.4 Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн хүнсний бүтээгдэхүүнээс дутсан 2402.3 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж, Төрийн сан дахь Орон нутгийн ерөнхий орлогын 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх.



2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Лүндээжанцан, нягтлан бодогч М.Батцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
О.БАТЖАРГАЛ
Ц.МӨНХЗАЯА



Аудитын үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэх маягт

Аудитын нэр		Санхүүгийн тайлангийн аудит	
Аудитын код		ӨВА-2022/150/НА-СТА-ТШЗ	
№	Аудитын үр өгөөжийн товч утга	Санхүүгийн үр өгөөж/ сая төгрөгөөр/	Санхүүгийн бус үр өгөөж / тоон утгаар/
1	Төсөвт зардлыг хэмнээгүй. 2022 оны санхүүгийн тайланд хэмнэлт гарна.	4.0	
Нийт дүн		4.0	
Шалгагдагч байгууллагын санал:			
Аудитын үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн: Байгууллагын нэр: Арвайхээр сумын 5-р цэцэрлэг		Албан тушаал: Эрхлэгч Нэр: Ц.Лүндээжанцан Гарын үсэг:  Огноо: 	
Бэлтгэсэн: Аудитор:  Ц.Мөнхзаяа Огноо: 2022.02.08		Хянасан: Аймгийн Аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор:  О.Батжаргал Аудитын менежер:  Д.Гансүх Огноо: 2022.02.08	

АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

Аудитын нэр: Арвайхээр сумын 5-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудит		Аудитор: Ц.Мөнхзаяа	
		Аудитын менежер: Д.Гансүх	
Аудитын код: ӨВА-2022/150/НА-СТА-ТШЗ		Тэргүүлэх аудитор: О.Батжаргал	
№	Аудитын үр өгөөжийн товч утга	Санхүүгийн үр өгөөж /сая төгрөгөөр/	Санхүүгийн бус үр өгөөж /тоон утгаар/
1	Тайлант онд 2.4 сая төгрөгийн хүнсний материал дутсан, 1,6 сая төгрөгийг ажилчдын хувцас бэлтгэх, уралдаан тэмцээн зохион байгуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан ЗГ-ын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй.	4.0 сая	

Аудитын үр өгөөжийг бүртгэх, хариуцах:

Аудитор:  Ц.Мөнхзаяа

2022 оны 02-р сарын 08